

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2025/013/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn
Аудитор: Х.Энхтуяа
Утас: 89182456 Цахим хаяг: enkhtuyakh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.ЭРДЭНЭНАРАН ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 1/324
танай _____ -ны № _____ -т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 7,738.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын бүрдэлт, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт, худалдан авах ажиллагааны төлөвлөлттэй холбоотой нийт 10.6 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг хүргүүлж байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэбулган сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж 92.5 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6725022218

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,414,086.6	9,079,951.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	569,165.2	8,161,811.8
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	128,409.5	150,441.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	711,511.9	762,699.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	5,000.0	5,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,095,884.4	2,313,535.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,095,884.4	2,313,535.4
39200	Биет хөрөнгө		2,057,183.6	2,160,780.2
39300	Биет бус хөрөнгө	13	38,700.8	152,755.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,509,971.0	11,393,487.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.0	65,847.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	0.0	65,847.7
41300	Өглөг	17а, 17б	0.0	10,819.7
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	0.0	55,028.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,509,971.0	11,327,639.6
51	Засгийн газрын хувь оролцоо		3,509,971.0	11,327,639.6
51100	Засгийн газрын оруулсан капитал		493,398.1	493,398.1
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		192,461.2	192,461.2
51200	Хуримтлагдсан үр дүн		1,489,456.3	9,307,125.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,334,655.4	1,334,655.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		3,509,971.0	11,393,487.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		1,510,158.8	9,887,693.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО		595,550.2	8,390,001.7
110	Орлогын албан татвар		318,132.3	572,116.9
1100	Хувь хүний орлогын албан татвар		342,270.2	572,116.9
113	Хөрөнгийн албан татвар		37,173.3	46,912.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж		240,244.7	7,770,972.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	51,656.3	344,101.0
120	Нийтлэг татварын бус орлого		51,656.3	344,101.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		862,952.2	1,153,591.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,870,629.1	2,069,966.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,870,629.1	2,011,288.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,437,294.8	1,976,763.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		498,880.0	792,576.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		81,737.7	101,730.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		10,799.9	154,472.8
2104	Хангамж, бараа материалын зардал		271,669.1	417,458.8
2105	Нормативт зардал		65.0	135.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		25,299.8	52,316.7
2107	Томилолт, зочны зардал		5,996.8	6,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		226,900.5	187,353.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		315,946.0	264,719.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		433,334.3	34,524.5

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	58,678.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-360,470.3	7,817,726.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		0.0	58.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-360,470.3	7,817,668.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,552,470.7	9,711,081.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	595,550.2	8,390,001.7
110	Орлогын албан татвар	318,132.3	572,116.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	342,270.2	572,116.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-24,137.9	0.0
113	Хөрөнгийн албан татвар	37,173.3	46,912.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	240,244.7	7,770,972.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	39,815.0	211,976.3
1181	Газрын төлбөр	20,199.8	51,683.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	180,229.9	7,507,312.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,968.2	167,488.7
120	Нийтлэг татварын бус орлого	93,968.2	167,488.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	862,952.2	1,153,591.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,647,812.6	1,652,559.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,647,812.6	1,652,559.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,010,254.3	1,618,035.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	498,880.0	786,915.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,737.7	98,571.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,694.0	154,672.8
2104	Хангамж, бараа материалын зардал	71,045.4	187,723.8
2105	Нормативт зардал	1,298.0	1,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,792.2	49,551.5
2107	Томилолт, зочны зардал	5,996.8	6,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	236,666.8	251,028.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,143.4	82,071.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	637,558.3	34,524.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-95,341.9	8,058,521.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,041,322.5	397,874.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,041,322.5	397,874.9
2200	Дотоод эх үүсвэрээр	1,041,322.5	397,874.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,041,322.5	-397,874.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-68,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	68,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,136,664.4	7,592,646.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,705,829.6	569,165.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	569,165.2	8,161,811.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,870,441.3	3,870,441.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,870,441.3	3,870,441.3
9	Тайлант үеийн үр дүн	-360,470.3	-360,470.3
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,509,971.0	3,509,971.0
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,509,971.0	3,509,971.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,509,971.0	3,509,971.0
19	Тайлант үеийн үр дүн	7,817,668.6	7,817,668.6
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	11,327,639.6	11,327,639.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,301,346.1	1,938,728.2	-362,617.9	84.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,621,470.1	1,386,692.3	-234,777.8	85.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,618,430.5	1,383,652.7	-234,777.8	85.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	786,930.3	786,915.6	-14.7	100.0
210101	Үндсэн цалин	726,039.3	678,719.7	-47,319.6	93.5
210102	Нэмэгдэл	58,891.0	89,747.2	30,856.2	152.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	7,605.0	7,605.0	
210104	Урамшуулал	2,000.0	10,843.7	8,843.7	542.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,571.8	98,571.8	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	67,388.8	67,388.8	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,795.7	7,795.7	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,897.9	3,897.9	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,897.9	3,897.9	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	15,591.5	15,591.5	0.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	359,786.4	154,672.8	-205,113.6	43.0
210301	Гэрэл, цахилгаан	61,344.9	45,603.9	-15,741.0	74.3
210302	Түлш, халаалт	288,961.5	96,289.8	-192,671.7	33.3
210303	Цэвэр, бохир ус	9,480.0	12,779.1	3,299.1	134.8
2104	Хангамж, бараа материалын зардал	71,134.2	71,130.7	-3.5	100.0
210401	Бичиг хэрэг	8,583.7	8,582.9	-0.8	100.0
210402	Тээвэр, шатахуун	33,937.6	33,937.6	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,049.0	4,049.0	0.0	100.0
210404	Ном, хэвлэл	100.0	100.0	0.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,500.0	13,500.0	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,963.9	10,961.2	-2.7	100.0
2105	Нормативт зардал	1,500.0	1,500.0	0.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500.0	1,500.0	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,000.0	48,771.6	-228.4	99.5

Эрдэнэбулган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,399.6	1,399.6	0.0	100.0
210602	Тавилга	3,500.0	3,500.0	0.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500.0	1,491.2	-8.8	99.4
210604	Урсгал засвар	42,600.4	42,380.8	-219.7	99.5
2107	Томилолт, зочны зардал	6,000.0	6,000.0	0.0	100.0
210701	Гадаад албан томилолт	0.0	0.0	0.0	
210702	Дотоод албан томилолт	6,000.0	6,000.0	0.0	100.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.0	0.0	0.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	164,144.7	134,727.2	-29,417.5	82.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	158,708.6	129,872.2	-28,836.5	81.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000.0	2,419.2	-580.8	80.6
210803	Даатгалын үйлчилгээ	244.5	244.3	-0.2	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	259.2	259.2	0.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	130.0	130.0	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500.0	1,500.0	0.0	100.0
210807	Газрын төлбөр	302.4	302.4	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,363.1	81,363.1	0.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,363.1	78,363.1	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000.0	3,000.0	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,039.6	3,039.6	0.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,039.6	3,039.6	0.0	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000.0	2,000.0	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,039.6	1,039.6	0.0	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	611,876.0	484,035.9	-127,840.1	79.1
223001	Бусад хөрөнгө	611,876.0	484,035.9	-127,840.1	79.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	68,000.0	68,000.0	0.0	100.0
230001	Эргэж төлөгдөх зээл	68,000.0	68,000.0	0.0	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,301,346.1	1,877,374.1	-423,972.0	81.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	275,468.7	275,468.7	0.0	100.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	275,468.7	275,468.7	0.0	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,469,420.7	1,552,330.0	82,909.3	105.6
320001	Орон нутгийн төсвөөс	1,469,420.7	1,552,330.0	82,909.3	105.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	556,456.7	49,575.3	-506,881.4	8.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,000.0	46,227.7	-19,772.3	70.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000.0	3,347.6	-652.4	83.7
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	486,456.7	0.0	-486,456.7	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	212,614.2	212,614.2	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	151,260.0	151,260.0	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,625.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	74,625.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,141.0
2104	Хангамж, бараа материалын зардал	732.2
210402	Тээвэр, шатахуун	732.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,700.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,700.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	708.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	708.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,484.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,484.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,484.9
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	74,625.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,625.9
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,315.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,310.9
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,000.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн ерөнхий орлого болон төсвийн шууд захирагчийн 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Үүнд:

№	Байгууллагын нэр	Аудитын дүгнэлт
1	Засаг даргын Тамгын газар	Өөрчлөлтгүй дүгнэлт
2	“Дүгийн-Эх” ОНӨААТҮГ	Өөрчлөлтгүй дүгнэлт
3	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Түүвэрт хамрагдсан
4	Сум хөгжүүлэх сан	Түүвэрт хамрагдсан
5	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 861.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 62.1 сая төгрөгийн 4 алдааг залруулж ,2.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 3 албан шаардлага хүргүүлж, 797.0 сая төгрөгийн 12 зөвлөмжийг өгсөн байна.

Аудитаар орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын бүрдэлт, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт , худалдан авах ажиллагааны төлөвлөлттэй холбоотой нийт 10.6 сая төгрөгийн 3 зөвлөмжийг хүргүүлж байна.

3.1 Төлбөрийн акт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

3.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл орон нутгийн орлогоос ан амьтны нөөц ашигласны төлбөр 9.2 сая төгрөгөөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 1.4 сая төгрөгөөр нийт 10.6 сая төгрөгөөр орлого тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Эрдэнэбулган сумын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хянаж үзэхэд нээлттэй болон харьцуулалтын аргаар тендэр зарлах боломжтой ижил төрлийн ажлуудыг жижиглэн, үнийн дүнг багасган шууд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан зөрчилтэй асуудал илэрлээ. Тухайлбал: Сумын төвийн зам арчилгаа, засварын нийт 44.6 сая төгрөгийн ажлыг 4 хуваан дараах байдлаар шууд худалдан авалтыг зохион байгуулж ажилласан байна.

Цахим дэлгүүрээс тэжээлийн үйлдвэр хүртэлх зам арчилгаа 11.9 сая төгрөг
Билэг дэлгүүрээс Цахим дэлгүүр хүртэлх зам арчилгаа 16.0 сая төгрөг
Гурван замын уулзвараас Баярын талбай хүртэлх зам арчилгаа 12.7 сая төгрөг
Сумын төвийн зам арчилгаа 4.0 сая төгрөг

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 10 дугаар зүйлийн 10.3. Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж

Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үнийн дүнг хуваахгүй нийт дүнгээр нь зохион байгуулах.

3. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн, хяналт дотоод аудитын албанаас ирүүлсэн чиглэлийн дагуу дотоод хяналт шалгалтын удирдамжийг сумын Засаг даргаар батлуулан шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, хүний нөөцийн цахим системтэй холбоотой дотоод хяналтыг хийж ажилласан байна. Харин Төсвийн төвлөрүүлэн Захирагчийн дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2024 оны А/06 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан боловч дотоод хяналтын нэгж нь тайлант онд дотоод хяналтаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулаагүй, хийгдсэн тодорхой үр дүнтэй ажил байхгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 2.3. "Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино" гэсэн заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрдэнэбулган сумын ТТЗ												
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Харьяа байгууллагуудын алдаа												
Эрдэнэбулган сумын ИТХ	1	3.3	1	3.3			1	3.3				
Эрдэнэбулган сумын ЗДТГ	2	6.3	1	5.0	1	1.3	2	6.3				
Дүгийн-Эх ОНӨААТҮГ	1	52.5	1	52.5			1	52.5				
ДҮН	4	62.1	3	60.8	1	1.3	4	62.1				
нийт дүн	4	62.1	3	60.8	1	1.3	4	62.1				

2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрдэнэбулган сумын ТТЗ	1	10.6					1	10.6				
Дүн	1	10.6					1	10.6				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Эрдэнэбулган сумын ЗДТГ	4	17.2	1	0.8	1	0.0	2	16.4				
Дүгийн-Эх ОНӨААТҮГ	7	41.8	1	1.2	2	0.0	4	40.6				
Дүн	11	59.0	2	2.0	3	0.0	6	57.0				
нийт дүн	12	69.6	2	2.0	3	0.0	7	67.6				

3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Эрдэнэбулган сумын ТТЗ	2	0.0					2	0.0
Харьяа байгууллагуудын зөрчил								
Эрдэнэбулган сумын ЗДТГ	3	729.4					3	729.4
Дүн	3	729.4					3	729.4
нийт дүн	5	729.4					5	729.4

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	5	1	4		1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	6	2	4		2			